



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Алтанширээ сумын Засаг даргын тамгын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2021/9/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Сайншанд сум

2021 он

Дарга, тэргүүлэх аудиторын үүргийг түр орлон гүйцэтгэгч:
Т.Ган-Өлзий

Утас: 7052-2734

Цахим хаяг: Gan-Ulziit@audit.gov.mn

Аудитын менежер: У.Оюунтүлхүүр

Утас: 7052-3020 Цахим хаяг:
Oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Ч.Хэрлэнчимэг

Утас: 70523020 Цахим хаяг:
Kherlenchimegch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СХАА	Санхүүгийн хяналт, аудитын алба
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	11
3. Аудитын тайлан.....	11
3.1. Ерөнхий зүйл.....	12
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй.....	12
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт	13
3.4. Материаллаг байдал	13
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл.....	15
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
3.9. Аудитын илрүүлэлт.....	16
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	16
Аудитын зөвлөмж.....	16
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	17
4. Менежментийн захидал	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

1.Төрийн аудитын санал, дүгнэлт



**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

2021.02.26 № 16/269

танай _____-ны № _____-т

АЛТАНШИРЭЭ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА М.БААСАНЖАВ
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Алтанширээ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Алтанширээ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын жилийн тайланд орсон, санхүүгийн тайлан ба аудиторын тайлангаас бусад мэдээлэл байхгүй байна.

Аудитын гол асуудал

Батлагдсан төсвөөс 5,663.0 мянган төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалын холбогдох заалтыг зөрчсөн.

Тогтмол шинж чанартай, давтагдах шинжтэй 6,105.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.4 дэх заалт, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар батлагдсан журмын зөрчсөн.

Бараа, үйлчилгээг тооцооны дансанд тусгахгүйгээр шууд зардалд тусгасан нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан журмын холбогдох заалтыг зөрчсөн байна.

Дээрх алдаа, зөрчлүүд үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Мөн аудитын явцад залруулах боломжтой алдаа илэрсэн боловч, нягтлан бодогч анхан шатны баримт материалыг бүрэн ирүүлээгүйн улмаас алдааг залруулах боломжгүй байв.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  Т.ГАН-ӨЛЗИЙ



2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>40,095,350.30</u>	<u>34,431,831.21</u>
33	АВЛАГА	-	1,839,334.21
335	Бусад авлага	-	1,839,334.21
3351	Байгууллагаас авах авлага	-	1,839,334.21
35	БАРАА МАТЕРИАЛ	40,095,350.30	32,592,497.00
354	Хангамжийн материал	32,555,350.30	20,087,497.00
35410	Бичиг хэргийн материал	592,200.00	472,698.00
35420	Аж ахуйн материал	30,963,150.30	17,731,399.00
35440	Түлш, шатах тослох материал	1,000,000.00	1,883,400.00
35600	Мал амьтад	7,540,000.00	12,505,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,585,043,857.40</u>	<u>1,781,757,326.25</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,585,043,857.40	1,781,757,326.25
392	Биет хөрөнгө	1,513,319,857.44	1,707,724,701.29
39201	Барилга, байгууламж, орон сууц	845,681,010.00	845,681,010.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(42,275,135.04)	(61,912,702.56)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	262,298,800.00	310,318,800.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(81,285,033.46)	(108,581,000.08)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	91,683,487.18	121,723,761.18
39206	Хуримтлагдсан элэгдэл	(45,059,689.66)	(51,270,065.90)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	64,427,337.48	68,427,337.48
39208	Хуримтлагдсан элэгдэл	(51,197,967.68)	(52,781,348.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	830,706,423.29	1,031,793,333.29
39215	Хуримтлагдсан элэгдэл	(361,659,374.67)	(395,674,423.80)
393	Биет бус хөрөнгө	71,723,999.96	74,032,624.96
39303	Бусад биет бус хөрөнгө	73,272,500.00	75,758,500.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	(1,548,500.04)	(1,725,875.04)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,625,139,207.70</u>	<u>1,816,189,157.46</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,625,139,207.70</u>	<u>1,816,189,157.46</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,625,139,207.70	1,816,189,157.46
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,105,559,518.71	1,105,559,518.71
51101	Өмч: - төрийн	1,105,559,518.71	1,105,559,518.71
512	Хуримтлагдсан үр дүн	(148,699,288.20)	42,350,661.56
51210	Өмнөх үеийн үр дүн	(148,699,288.20)	(148,699,288.20)
51220	Тайлант үеийн үр дүн	-	191,049,949.76
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	668,278,977.19	668,278,977.19
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,625,139,207.70</u>	<u>1,816,189,157.46</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	641,996,696.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	298,180,971.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	298,180,971.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	800,000.00
120009	Бусад орлого	-	10,625,000.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	-	280,668,184.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	-	6,087,787.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	343,815,725.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	28,806,525.21
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,806,525.21
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	315,009,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	315,009,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	450,946,746.45
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	450,946,746.45
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	447,273,996.45
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	216,889,994.00
210101	Үндсэн цалин	-	216,889,994.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	26,705,138.00
210201	Тэтгэврийн даатгал	-	18,119,438.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,146,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,717,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	821,510.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	3,900,090.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	24,180,675.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,940,433.00
210302	Түлш, халаалт	-	19,085,242.00
210303	Цэвэр, бохир ус	-	105,000.00
210304	Байрны түрээс	-	50,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	47,810,161.30
210401	Бичиг хэрэг	-	3,809,280.00
210402	Тээвэр, шатахуун	-	10,548,911.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,580,430.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	386,800.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	-	29,364,740.30
2105	Нормативт зардал	-	285,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	285,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	5,270,900.00
210604	Урсгал засвар	-	5,270,900.00
2107	Томилот, зочны зардал	-	3,756,900.00
210702	Дотоод албан томилот	-	3,756,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	32,147,223.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	30,886,659.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	598,464.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	212,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	180,000.00
210807	Газрын төлбөр	-	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	90,228,005.15
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,308,290.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	88,919,715.15

Алтанширээ сумын Засаг даргын тамгын газрын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,672,750.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	450,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	450,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,222,750.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,222,750.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	=	191,049,949.76
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	=	191,049,949.76

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	<u>344,615,725.21</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	800,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	-	800,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	800,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	800,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	343,815,725.21
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	28,806,525.21
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,806,525.21
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	315,009,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	315,009,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	<u>342,776,391.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	342,776,391.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	338,753,641.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	214,669,000.00
210101	Үндсэн цалин	-	214,669,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	26,833,600.00
210201	Тэтгэврийн даатгал	-	18,246,900.00
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,146,800.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,717,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	-	429,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	-	4,293,300.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	22,515,569.00
210301	Гэрэл, цахилгаан	-	4,849,327.00
210302	Түлш, халаалт	-	17,379,242.00
210303	Цэвэр, бохир ус	-	287,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	18,702,515.00
210401	Бичиг хэрэг	-	3,295,160.00
210402	Тээвэр, шатахуун	-	10,955,500.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	3,540,355.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	791,500.00
2105	Нормативт зардал	-	179,400.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	179,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	6,480,000.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	5,000,000.00
210604	Урсгал засвар	-	1,480,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,756,900.00
210702	Дотоод албан томилолт	-	3,756,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	38,745,066.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	37,484,502.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	230,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	-	598,464.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	212,100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	180,000.00
210807	Газрын төлбөр	-	40,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	6,871,591.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	1,871,591.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	4,022,750.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	800,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	800,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	3,222,750.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	3,222,750.00
213405	Нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,839,334.21
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	<u>1,839,334.21</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	1,839,334.21
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	669,094,120.77	(165,033,471.25)	1,609,620,168.23
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	815,143.58	815,143.58
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,105,559,518.71	669,094,120.77	(164,218,327.67)	1,610,435,311.81
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(815,143.58)	-	(815,143.58)
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	15,519,039.47	-	15,519,039.47
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	683,798,016.66	(164,218,327.67)	1,625,139,207.70
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	668,278,977.19	(148,699,288.20)	1,625,139,207.70
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,105,559,518.71	683,798,016.66	(164,218,327.67)	1,625,139,207.70
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	191,049,949.76	191,049,949.76
D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,105,559,518.71	668,278,977.19	42,350,661.56	1,816,189,157.46

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	317,772,000.00	312,586,450.00	5,185,550.00	98%
21	УРСГАЛ ЗАРДАЛ	317,772,000.00	312,586,450.00	5,185,550.00	98%
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	316,972,000.00	311,786,450.00	5,185,550.00	98%
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	214,669,000.00	214,669,000.00	-	100%
210101	Үндсэн цалин	214,669,000.00	214,669,000.00	-	100%
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	26,833,600.00	26,833,600.00	-	100%
210201	Тэтгэврийн даатгал	18,246,900.00	18,246,900.00	-	100%
210202	Тэтгэмжийн даатгал	2,146,800.00	2,146,800.00	-	100%
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,717,300.00	1,717,300.00	-	100%
210204	Ажилгүйдлийн даатгал	429,300.00	429,300.00	-	100%
210205	Эрүүл мэндийн даатгал	4,293,300.00	4,293,300.00	-	100%
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	22,737,800.00	22,515,569.00	222,231.00	99%
210301	Гэрэл, цахилгаан	2,219,000.00	4,849,327.00	(2,630,327.00)	219%
210302	Түлш, халаалт	19,996,100.00	17,379,242.00	2,616,858.00	87%
210303	Цэвэр, бохир ус	522,700.00	287,000.00	235,700.00	55%
2104	Хангамж, бараа материалын зардал	17,561,800.00	17,274,215.00	287,585.00	98%
210401	Бичиг хэрэг	3,244,300.00	3,230,160.00	14,140.00	100%
210402	Тээвэр, шатахуун	9,721,000.00	9,721,000.00	-	100%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,676,500.00	3,411,555.00	264,945.00	93%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00	-	100%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	800,000.00	791,500.00	8,500.00	99%
2105	Нормативт зардал	200,000.00	179,400.00	20,600.00	90%
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	200,000.00	179,400.00	20,600.00	90%
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,480,000.00	6,480,000.00	-	100%
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210604	Урсгал засвар	1,480,000.00	1,480,000.00	-	100%
2107	Томилолт, зочны зардал	7,259,700.00	3,235,000.00	4,024,700.00	45%
210702	Дотоод албан томилолт	7,259,700.00	3,235,000.00	4,024,700.00	45%
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,330,100.00	13,728,075.00	602,025.00	96%
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,848,000.00	12,467,511.00	380,489.00	97%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	230,000.00	230,000.00	-	100%
210803	Даатгалын үйлчилгээ	743,600.00	598,464.00	145,136.00	80%
210804	Тээврийн хэрэгслийн татвар	288,500.00	212,100.00	76,400.00	74%
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	180,000.00	180,000.00	-	100%
210807	Газрын төлбөр	40,000.00	40,000.00	-	100%
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,900,000.00	6,871,591.00	28,409.00	100%
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.00	5,000,000.00	-	100%
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,900,000.00	1,871,591.00	28,409.00	99%
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	800,000.00	800,000.00	-	100%
2132	Бусад урсгал шилжүүлэг	800,000.00	800,000.00	-	100%
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	800,000.00	800,000.00	-	100%

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	317,772,000.00	315,809,200.00	1,962,800.00	99%
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	316,972,000.00	315,009,200.00	1,962,800.00	99%
132001	Орон нутгийн төсвөөс	316,972,000.00	315,009,200.00	1,962,800.00	99%
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	800,000.00	800,000.00	-	100%
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	800,000.00	800,000.00	-	100%

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	26,967,191.00	(26,967,191.00)
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	26,967,191.00	(26,967,191.00)
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	26,967,191.00	(26,967,191.00)
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,428,300.00	(1,428,300.00)
210401	Бичиг хэрэг	-	65,000.00	(65,000.00)
210402	Тээвэр, шатахуун	-	1,234,500.00	(1,234,500.00)
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	128,800.00	(128,800.00)
2107	Томилолт, зочны зардал	-	521,900.00	(521,900.00)
210702	Дотоод албан томилолт	-	521,900.00	(521,900.00)
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	25,016,991.00	(25,016,991.00)
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	25,016,991.00	(25,016,991.00)
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	28,806,525.21	(28,806,525.21)
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	28,806,525.21	(28,806,525.21)
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	28,806,525.21	(28,806,525.21)

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Алтанширээ сумын ЗДТГ-ын дарга М.Баасанжав танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материалын орлого болон зарцуулалтыг нягтлан бодох бүртгэлд тусгахдаа анхан шатны баримтат үндэслэх, бараа материалын гүйлгээг шууд зардалд тусгахгүй байх талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 19-нөөс 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Хэрлэнчимэг хариуцаж хэрэгжүүлэв.

Алтанширээ сумын ЗДТГ-ын 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2021 оны 01 дүгээр сарын сарын 18-ны өдрийн 1/36 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Алтанширээ сумын ЗДТГ-ын үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нутаг дэвсгэрт төрийн бүх шатны бодлого зорилгыг зохион байгуулан хэрэгжүүлж, Засаг даргаас үйл ажиллагаагаа явуулах явуулах нөхцөлийг бүрдүүлэн мэргэжлийн зөвлөгөө дэмжлэгээр хангах,
- Нутаг дэвсгэрийн орон нутаг дахь байгууллагуудын салбар хоорондын уялдаа холбоог хангах, тэдгээр байгууллагуудыг бодлогын удирдамж, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах,
- Нутаг дэвсгэрийн хөгжлийн урт дунд богино хугацааны бодлого боловсруулах,
- Орон нутгийн амьдралын тулгамдсан асуудлыг шийдвэрлүүлэхийн зэрэгцээ биелэлтэд нь хяналт тавьж ажиллах,
- Төр, захиргааны байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ явуулж, хяналт шалгалтын мөрөөр гүйцэтгэлийг сайжруулах,
- Төр, захиргааны байгууллагын бүтцийн өөрчлөлт, чиг үүрэг, үйл ажиллагаатай уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэгжүүлж, төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг үе шаттайгаар хангах замаар Тамгын газрыг мэргэшсэн тогтвортой, чадварлаг алба байлгахад анхаарах,
- Төрийн албан хаагчийн мэдлэг боловсрол, мэргэшлийн ур чадвар, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахтай холбогдсон төсөл, хөтөлбөрийг үе шаттайгаар боловсруулж хэрэгжүүлэх,

- Төрийн албан хаагчдыг авлигал, хээл хахуульд авталгүй үнэнч шударга, төрийн албан тушаалтны ёс зүйн хэм хэмжээг чанд сахиулж ажиллах.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд өөрчлөлт ороогүй байна.

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Алтанширээ сумын ЗДТГ-ын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 онд Алтанширээ сумын ЗДТГ-ын санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

Аймгийн Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2020 оны шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажилладаг байна.

Алтанширээ сумын ЗДТГ-ын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “үр нөлөөгүй” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөгүй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр жилийн төсвийг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны нийт зардлын 236,352.7 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 2,363.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон. Үүнийг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзсэн. Материаллаг байдлыг жилийн санхүүгийн тайлангийн нийт зардал болох 450,946.7 мянган төгрөгөөс 1 хувиар тооцож, 4,509.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тогтоов.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Алтанширээ сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,671.9 мянган төгрөгөөр буюу 1.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	1,839.30	1,839.30
Урьдчилгаа	-	-	-
Бараа материал	40,095.40	32,592.50	(7,502.90)
Үндсэн хөрөнгө	1,585,043.80	1,781,757.30	196,713.50
Нийт хөрөнгө	1,625,139.20	1,816,189.10	191,049.90

Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,625,139.20	1,816,189.10	191,049.90
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,625,139.20	1,816,189.10	191,049.90

Авлага дансны үлдэгдэл 1,839.3 мянган төгрөг болж өссөн нь нэмэлт санхүүжилтийн төвлөрүүлэх шилжүүлгийг авлагаар бүртгэж тайлагнасантай холбоотой байна.

Нийт авлагын дүнд барагдах боломжгүй болон удаан жил болсон авлага байхгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 32,592.50 мянган төгрөг болж 7,502.90 мянган төгрөгөөр буурсан нь нь тайлант онд ашиглагдахгүй хуучин аж ахуйн материалыг данснаас хассантай холбоотой.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл /үлдэгдэл өртгөөрөө/ 1,781,757.30 мянган төгрөг болж 196,713.5 мянган төгрөгөөр өссөн нь ОНХС-аар хийгдсэн ажлыг бүртгэсэн, мөн өмнөх онд улс болон ОНХО-аар хийгдсэн ажлыг бүртгэл тайланд тусгаагүй байсныг тайлант онд тусгажээ. Үндсэн хөрөнгийн данс нь хөрөнгө оруулалтаар 274,398.2 мянган төгрөг, урсгал төсвийн худалдан авалтаар 4,965.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 6,270.0 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Биет бус хөрөнгө 2,486.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд нягтлан бодогч болон эд хариуцагчийн программ шинээр нэмэгдсэнтэй холбоотой.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,816,189.1 мянган төгрөг болж, 191,049.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 191,049.9 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Алтанширээ сумын ЗДТГ-ын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 166,399.4 мянган төгрөгөөр буюу 34.9 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан дээд шатны байгууллагаас шилжүүлсэн эрх шилжүүлсэн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн орлого байна.

Нийт зардал өмнөх оноос 9,116.3 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 370,230.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 370,230.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 52,458.4 мянган төгрөгөөр бууруулж, 317,772.0 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн төсөлд тусгагдсан зардлаас урсгал засварын зардлыг материаллаг дүнгээр бууруулж баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 317,772.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 316,972.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 800.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 315,009.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 800.0 мянган төгрөгийг, нийт 315,809.2 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 312,586.4 мянган төгрөгийг зарцуулж 3,222.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 312,586.4 мянган төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь дотоод албан томилолтын зардлыг 4,024.7 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 22,701.6 мянган төгрөг, тусгах үйл ажиллагааны хүрээнд 6,105.0 мянган төгрөг, нийт 28,806.6 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээнд 25,017.0 мянган төгрөг, хангамж бараа материал болон томилолтын зардалд 1,950.2 мянган төгрөг, нийт 26,967.2 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 1,839.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлж, авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд хуульд нийцээгүй 6,105.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлсэн байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 50 мэдээллээс хугацаандаа оруулсан 49 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 1 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 2,100.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 1 албан шаардлага, 100.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн актыг бүрэн хэрэгжүүлсэн байна. Аудитаар өгсөн 1,200.0 мянган төгрөгийн 2 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувь хэрэгжүүлсэн гэсэн баримт, тайлбар ирүүлсэн боловч, 2020 онд уг зөрчил давтагдсан байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	100.0	1	100.0	-	-	100
Албан шаардлага	1	2,100.0	1	2,100.0	-	-	100
Зөвлөмж	2	1,200.0	1	-	1	1,200.0	50
Нийт дүн	4	3,400.0	2	900.0	1	1,200.0	83,3

Аудитаар давтагдах шинжтэй, тогтмол орлого болох туслах үйл ажиллагааны орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн зөвлөмж хэрэгжээгүй байгаад албан шаардлага өгөхөөр шийдвэрлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 115,843.8 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 32,387.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 83,456.5 мянган төгрөгийн зөрчилд алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өглөө.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 115,843.8 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 32,387.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлсэн. Үүнд:

1. Зориулалт бусаар 5,663.0 мянган төгрөгийн зардлыг зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”*, Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан журамд заасан эдийн засгийн ангиллыг зөрчиж, үнэн зөв батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх тухай албан шаардлагыг хүргүүлэв.

2. Туслах үйл ажиллагаанаас төвлөрүүлдэг, тогтмол, давтагдах шинжтэй 6,105.0 мянган төгрөгийн орлогыг нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлж, зарцуулсан байна. Тус зөрчилд өмнөх оны аудитаар зөвлөмж өгсөн боловч, зөрчлийг давтан гаргасан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлэв.

3. Өмнөх онд нэмэлт санхүүжилтийн дансны үлдэгдэл болох 1,839.3 мянган төгрөгийг Төрийн санд төвлөрүүлж, авлагаар бүртгээгүй ба уг шилжүүлгийг тайланд онд нэмэлт санхүүжилтийн дансанд шилжүүлсэн байна. Үүнийг өмнөх оны үр дүнд тусгаж, залруулах байтал, тайлант оны орлогоор хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна. Аудитын явцад уг алдааг залруулах боломжгүй байна.

Малын нас дэвшилтийн орлогыг бүртгэхдээ зөвхөн нас дэвшсэн дүнг орлогоор хүлээн зөвшөөрөх байтал нас дэвшүүлсэн болон нас дэвшээгүй байх үеийн нийт дүн болох 10,625.0 мянган төгрөгийг орлогоор зөвшөөрсөн байна. Аудитын явцад орлогыг бууруулж залруулах байтал нас дэвшилтийн баримт материалыг ирүүлээгүй болно. Мөн 8,155.0 мянган төгрөгийн бараа материал, хөрөнгийг иргэн, ААН-ээс үнэ төлбөргүй хүлээн авсан гэж бүртгэлд тусгасан байна. Энэ нь хандив эсэх болон дээд шатны байгууллагаас зөвшөөрөл авсан эсэхийг аудитын явцад нотлох боломжгүй байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2-т *“санхүүгийн аливаа үйл ажиллагааг ... үнэн зөв бүртгэж, тайлагнах”* гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгах тухай албан шаардлагыг хүргүүлэв.

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 83,456.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 6 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Тайлант онд нийт 3,508.0 мянган төгрөгийн түрээсийн орлогыг төвлөрүүлж, үүнээс 1,840.0 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт шилжүүлэхдээ бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардалд тусгасан байна. Энэ нь орлого болон зардлыг хийсвэрээр нэмэгдүүлсэн байх ба уг асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагчийн тайланд нэгтгэн, шийдвэрлэх нь зүйтэй байна.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

Балансын данстай холбоотой үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 1.1. Илрүүлэлт: Байгууллагад ашиглагдаж байгаа, 2018-2019 онуудад бүртгэсэн нийт 86,269.7 мянган төгрөгийн 36 нэр төрлийн 113 ширхэг үндсэн хөрөнгийн ашиглах жилийг тогтоогоогүй, элэгдлийн зардлыг одоог хүртэл тооцоогүй байна.
- 1.2. Эрсдэл: Элэгдлийн зардал буруу илэрхийлэгдэх.
- 1.3. Өгсөн зөвлөмж: Элэгдлийн зардлыг нөхөн тооцож, хуримтлагдсан элэгдлийг үнэн зөв бүртгэх.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Балансын данстай холбоотой үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 2.1. Илрүүлэлт: Тухайн байгууллагад нийт 194,336.7 мянган төгрөгийн 122 төрлийн 227 ширхэг, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн үндсэн хөрөнгө ашиглагдаж байна.
- 2.2. Эрсдэл: Элэгдлийн зардал буруу илэрхийлэгдэх.
- 2.3. Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа хөрөнгийг дахин үнэлж бүртгэх. Ашиглалтын шаардлага хангахгүй хөрөнгийг данснаас хасаж, актлах асуудлыг холбогдох байгууллагаар шийдвэрлүүлэх.
- 2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Зардлын данстай холбоотой үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 3.1. Илрүүлэлт: Зардлын ангиллыг түүвэрлэн шалгахад нийт 8,601.6 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж бүртгэсэн байна.
- 3.2. Эрсдэл: Зардал буруу илэрхийлэгдэх.
- 3.3. Өгсөн зөвлөмж: Буруу ангилан бүртгэгдсэн зардлыг зориулалт, ангиллын дагуу анхан шатны баримтат үндэслэн залруулж бүртгэх, цаашид уг алдааг давтан гаргахгүй байх.
- 3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Зардлын данстай холбоотой үйл ажиллагаатай холбоотой асуудал

- 4.1. Илрүүлэлт: Тайлант онд нийт 24,899.0 мянган төгрөгийн 96 гүйлгээг тооцооны дансанд тусгахгүйгээр шууд зардалд тусгасан байна. Үүнээс 6,578.5 мянган төгрөгийн 20 гүйлгээ нь бараа материалыг шууд зардлаар тусгасан гүйлгээ байна. Эдгээр гүйлгээг аудитын явцад залруулах боломжгүй байсан ба бараа материалын зарцуулалттай холбоотой анхан шатны баримтыг ирүүлээгүй болно.
- 4.2. Эрсдэл: Бараа материалын үлдэгдэл болон зардал буруу илэрхийлэгдэх.

- 4.3. Өгсөн зөвлөмж: Тооцооны дансанд тусгахгүйгээр бүртгэсэн зардал болон бараа материалыг анхан шатны баримтыг үндэслэн тооцооны данс болон бараа материалын дансанд бүртгэж, зарцуулан залруулах.
- 4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Нягтлан бодох бүртгэлтэй холбоотой асуудал

- 5.1. Илрүүлэлт: Цалингаас суутгасан НДШ, ХХОАТ, болон бусад суутгалыг цалингийн өглөг бууруулах бичилт хийхгүйгээр шууд зардалд тусгаж, холбогдох байгууллагад өглөг үүсгэсэн байна. Нийт 49,955.9 мянган төгрөгийн гүйлгээг буруу тусгасан байна. Эдгээр гүйлгээг аудитын явцад залруулах боломжгүй байв.
- 5.2. Эрсдэл: Өглөг, авлага буруу илэрхийлэгдэх.
- 5.3. Өгсөн зөвлөмж: Буруу бүртгэсэн цалингийн гүйлгээг залруулан бүртгэх.
- 5.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дотоод хяналттай холбоотой асуудал

- 6.1. Илрүүлэлт: Тус байгууллага нь малын ноолуур борлуулсны орлого, буудлын төлбөрийн орлого, орон сууц түрээслүүлсний төлбөр, усны машин түрээслүүлсэн төлбөр, усны карт цэнэглэсэн орлого, нийт 5 төрлийн орлогоос 6,905.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн байна. Ноолуурын орлогоос 700.0 мянган төгрөгийг бүрдүүлсэн боловч хэдэн кг ноолуур авсан, түүнийг хэдэн төгрөгөөр борлуулсан эсэхийг нотлох баримт байхгүй байна. Мөн буудлын төлбөрийг хурааж авахдаа тасалбар харилцагчид тасалбар өгдөг гэх боловч аудитын явцад тасалбар болон холбогдох тооцооллыг ирүүлээгүй. Түрээсийн орлогыг түрээсийн гэрээ болон тооцоолол хийсэн баримтыг аудитын явцад ирүүлээгүй болно.
- 6.2. Эрсдэл: Орлого болон авлага, өглөг буруу илэрхийлэгдэх, мөнгөн хөрөнгө шамшигдах.
- 6.3. Өгсөн зөвлөмж: Туслах үйл ажиллагаанаас бүрдүүлсэн орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг шалгах, орлогын бүрдүүлэлтэд тавих дотоод хяналтыг сайжруулж, анхан шатны баримтад үндэслэн орлогыг бүртгэх
- 6.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо:	Аудитын нэр:	Алтанширээ сумын ЗДТГ-ын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код:
2021			ДГА-2021/9/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Алтанширээ сумын ЗДТГ		Мянган төгрөг

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Санхүүгийн тайланд тусгасан орлогыг буруу бүртгэсэн, нотлох баримт байхгүй	20,619.3	Албан шаардлага	Тамгын газрын дарга, нягтлан бодогч	М.Баасанжав, О.Бямбасүрэн
2	Байгууллагын дансанд бүртгэлтэй нийт 86,269.7 мянган төгрөгийн 113 ширхэг үндсэн хөрөнгөд элэгдэл тооцогдоогүй байна.	-	Зөвлөмж өгөх		
3	Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	5,663.0	Албан шаардлага		
4	НДШ, ХХОАТ болон бусад суутгалыг буруу бүртгэдэг	49,955.9	Зөвлөмж өгөх		
5	Нийт 24,899.0 мянган төгрөгийн бараа материал болон харилцагч байгууллагаас үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэхдээ шууд зардалд тусгасан	24,899.0	Зөвлөмж		
6	Тухайн байгууллагад нийт 194,336.7 мянган төгрөгийн 122 төрлийн 227 ширхэг үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн байна.	-	Зөвлөмж		
7	Зардлын ангиллыг түүвэрлэн шалгахад нийт 8,601.6 мянган төгрөгийн зардлыг буруу ангилж бүртгэсэн байна.	8,601.6	Зөвлөмж		
8	Нэмэлт санхүүжилтийн дансанд тайлант хугацаанд нийт 28,806.5 мянган төгрөгийн орлого орсон байна. Эдгээр орлогыг хууль, журамд нийцсэн эсэхийг шалгахад нийт 6,105.0 мянган төгрөгийн тогтмол, давтагдах шинжтэй /орон сууцны түрээсийн төлбөр, усны машины түрээсийн төлбөр, усны карт цэнэглэлтийн орлого/ орлогыг бүрдүүлсэн байна.	6,105.0	Албан шаардлага		
9	Туслах үйл ажиллагаанаас төвлөрүүлсэн орлогын дүн нотлох боломжгүй, орлогыг бүрэн төвлөрүүлсэн эсэхийг нотлох анхан шатны баримт байхгүй байна.	-	Зөвлөмж		
ДҮН		115,843.8			